



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/306

Алтай хот

“Булагийн өдөр” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жил бүрийн 5, 10 дугаар сарын сүүлийн долоо хоногийн даваа гарагийг аймгийн хэмжээнд булаг шанд, уст цэгийн ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг цэвэрлэх, байгалийн голдирлыг сэргээх, тохижуулах, хамгаалах, засаж сэлбэх өдөр болгосугай.

2. Тус өдрүүдэд сумын хэмжээнд уст цэгийн орчны хог хаягдлыг цэвэрлэх, хашиж хамгаалах, хамгаалалтын тор, шонг засах ажлыг олон нийтийг оролцуулан үр дүнтэй зохион байгуулж хэвшихийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээг нэгдсэн удирдлага, мэргэшил арга зүйгээр хангаж, зөвлөн тусалж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Н.Доной), Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа (С.Жаргалзаяа)-нд тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г. Хурцгэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР